



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

2025 оны 3 дугаар сарын 31

Дугаар 1237

Улаанбаатар хот

Тамга, тэмдгийн хяналтын  
дугаар хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.7.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарг-ын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 14-д заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Эм Хаус Пропертис ХХК (6005772)-ийн Гүйцэтгэх захирал Ч.Дуулим-ын гаргасан хүсэлтэд “Эм Хаус Пропертис ХХК нь тамга, тэмдгээ хаяж үрэгдүүлсэн тул хяналтын дугаар шинээр олгож өгнө үү.” гэсний дагуу мэдээллийн санд бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд Эм Хаус Пропертис ХХК-нд 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр улсын бүртгэгч Ч.Батдэлгэр 1115210908 хяналтын дугаар олгосон бүртгэл, Монгол Улсын иргэн Ч.Дуулим 100 хувийн хувьцаа эзэмшиж байна. Гүйцэтгэх удирдлагаар Ч.Дуулим бүртгэлтэй байх бөгөөд өнөөдрийн байдлаар тус хуулийн этгээдэд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хоригийн бүртгэл бүртгэгдээгүй байна.

2.Эм Хаус Пропертис ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Дуулим гаргасан хүсэлт, түүнд хавсаргаж өгсөн нотлох баримтыг хянан үзэхэд: Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо, 13 хороолол, Энх тайваны өргөн чөлөө 47/9 Пристиж төв 407 тоот хаягт байршилтай, Эм Хаус Пропертис ХХК-ийн тамга, тэмдгийн хяналтын 1115210908 дугаартай тэмдгийг гээгдүүлсэн тухай 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, түүнд гүйцэтгэх захирал Ч.Дуулим-ын гарын үсэгтэй, 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн гүйцэтгэх захирал Ч.Дуулим-ын гарын үсэгтэй хүсэлт, Өнөөдөр сонины 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн №053(8117) дугаарт хүчингүйд тооцсон тухай зар зэрэг нотлох баримтаар Эм Хаус Пропертис ХХК нь тамга, тэмдгийн хяналтын 1115210908 дугаартай тэмдгийг гэсэн болох нь нотлогдож байна.

3.Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Эм Хаус Пропертис ХХК-ийг 500 нэгжээр торгож, энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 250 нэгжээр хөнгөрүүлж, торгож шийтгэл оногдуулсан тухай

1525030036

Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 0920354 дугаартай шийтгэлийн хуудас байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1-т “Хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт “Тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцож, хяналтын дугаарыг улсын бүртгэгч ажлын 2 өдрийн дотор дахин олгоно.” гэж заасныг тус тус баримтлан ДҮГНЭХ нь:


1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 6005772 регистрийн дугаартай Эм Хаус Пропертис ХХК-д олгосон тамга, тэмдгийн хяналтын 1115210908 дугаарыг хүчингүй болгох.

2.Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Эм Хаус Пропертис ХХК-д мэдэгдэх.

3.Байгууллагын цахим сайтад байршуулах арга хэмжээ авах.

Дүгнэлтийн хувийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлэх.

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



М.МӨНХГЭРЭЛ